

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК-Д ХАНДАН САНАЛ, ГОМДОЛ ГАРГАХ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

“Оюу толгой” ХХК нь орон нутгийн иргэд, байгууллагуудаас Оюу толгой уурхай болон компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, гомдлыг нээлттэй хүлээн авдаг.

Бид “Орон нутгийн санал, гомдол шийдвэрлэх журам”-ыг батлан гаргаж, энэ журмын дагуу бүх санал, гомдлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. Уг журам нь оролцогч талууд санал, гомдлоо ил тод, үр дүнтэй байдлаар илэрхийлэх суваг бүрдүүлэх, улмаар орон нутгийн оролцогч талуудтай ил тод, харилцан хүндэтгэл бүхий холбоо харилцааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой юм.

Орон нутгийн байгууллага, иргэдийн гаргасан санал, гомдлыг хэрхэн шийдвэрлэх үе шат, алхмуудыг дараагийн хуудаснаас үзнэ үү.

Орон нутгийн иргэд, байгууллагууд компанид хандан санал, гомдол гаргахдаа юуны өмнө санал, гомдлын маягт бөглөх ёстой. “Оюу толгой” ХХК-ийн Нийгмийн харилцааны хэлтсийн доор дурьдсан салбар оффисуудаас санал, гомдлын маягт авах боломжтой юм. Үүнд:

- **Ханбогд сум:** “Оюу толгой” ХХК-ийн Нийгмийн харилцааны хэлтсийн оффис;
- **Манлай сум:** “Оюу толгой” ХХК-ийн Нийгмийн харилцааны хэлтсийн оффис;
- **Даланзадгад:** Оюу толгойн төлөөлөгчийн газар;
- **Улаанбаатар:** Оюу толгойн төв оффис;

Амаар болон утсаар санал, гомдол гаргасан тохиолдолд “Оюу толгой” ХХК-ийн Нийгмийн харилцааны хэлтсийн ажилтнууд санал гомдол гаргагчийн мэдээлэлд үндэслэн маягтыг бөглөх болно.

Санал, гомдлын маягтыг www.ot.mn цахим хуудаснаас татаж авах боломжтой ба 9903-4732 утсаар холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Бид орон нутгийн оролцогч талуудын дуу хоолойг сонсох, тэднээс суралцахад үргэлж нээлттэй байдаг бөгөөд та бүхэн өөрсдийн санал, гомдлоо дээр дурьдсан хаягаар илгээнэ үү.

ОРОН НУТГААС ГАРГАСАН САНАЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АЛХМУУД

